

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

Хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол Улс, Бүгд Найрамдах Франц улс хоорондын найрамдалт харилцаа, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулах, өрсөлдөх чадвартай Монгол иргэнийг бэлтгэх, Монгол, Францын их, дээд сургууль, судалгаа, шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих, хөгжүүлэх Монгол улсад шинэ зорилгоор тус тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Нийт элсүүлэх оюутны тоо 10

Шалгуур үзүүлэлт

- **Ахисан түвшний хөтөлбөр(Хугацаа: 3-4 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг	1-2 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	<p>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;</p> <ol style="list-style-type: none">1. Өргөдөл гаргагч нь 25-35 нас хүртэлх Монгол улсын иргэн байх.2. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.3. Мэргэжлээрээ 3-5 жил ажилласан, Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн жагсаалт, сонгосон чиглэлээр суралцах сэдвийн хүрээнд бичсэн автореферат; магистрын сургалтад өргөдөл гаргах иргэд хавсаргах шаардлагагүй ч хавсаргавал давуу талтай)4. Франц дахь их, дээд сургуульд бүртгүүлэх шаардлага хангасан, Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын бакалаврын эсвэл магистрийн зэргийн дипломтай байх,5. Суралцахаар сонгосон сургууль, хөтөлбөрт тавигдах франц эсвэл англи хэлний түвшингийн шаардлагыг хангасан байх;6. Франц хэл:<ul style="list-style-type: none">○ DELF (Франц хэлний сургалтын диплом) 2 дахь шатны буюу CECRL –н B2 түвшин ;○ DALF (Франц хэлний гүнзгийрүүлсэн шатны диплом) ; TCF –н диплом B2 түвшингээс дээш болон нэмэлт шалгалтын диплом;7. Олон улсад хүчинтэй гадаад хэлний шалгалт өгч хангалттай оноо авсан байх. IELTS 6.5 аас дээш	

Францын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдагч дараах эрхийг эдэлнэ.

- Угтуулан тосох үйлчилгээ авна.
- Францын визний хураамжаас чөлөөлөгдөнө.
- Франц дахь сургалттай холбогдолтой зардал, хоол, байрны зардалд зориулагдсан сарын 767 € хүртэл мөнгөн тэтгэмж сургалтын хугацааны түрш авна.
- Онгоцны буудалд буусан даруй эхний тэтгэмж авахад Travelex үйлчилгээ авах эрх нээнэ.
- Эхний жилийн оршин суух зөвшөөрлийн хураамжийг буцаан авна.
- Сургалтын материал, номын төлбөрийг жилд нэг удаа буцаан авна.
- Хэрэв оюутан CROUS байгууллагын оюутны байранд хамрагдаж чадаагүй бол түрээсийн байрны төлбөрийг буцаан авах, мөн Францын их дээд сургуулийн оюутны байранд бүртгүүлэхэд давуу эрх эдлэнэ.
- Дээд сургуулийн бүртгэлийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- Франц улс дахь эрүүл мэндийн даатгалаас чөлөөлөгдөнө.

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Өргөдөл цаасан хэлбэрээр БНФранц Улсын Элчин сайдын яамны байранд хүлээн авна. Өргөдлийн маягт бөглөсөн байх. /Франц, Англи хэл дээр/

2



Сонгон шалгаруулалтыг баримт бичигт үнэлгээ өгөх, ярилцлага хийх гэсэн үе шаттай зохион байгуулна. Франц, Англи хэлээр, ярилцлаганд орно.

3



Холбоо барих

- Нэмэлт мэдээллийг Монгол дахь Франц Улсын ЭСЯ-ны ажилтан Т.Төрнямтай 11-324519 утсаар холбогдож

авна уу. Цахим хаяг: contact@ambafrance-mn.org